



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Хөрөнгө солилцон бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэн П.Энхбатын 2023 оны 8 дугаар хүсэлтийг үндэслэн түүний өмчлөлийн Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1-р баг, Зэст 1 дүгээр хороолол, 16 дугаар байрны 58 тоот хаягт байрлах, нийт 120,300,362.00 (нэг зуун хорин сая гурван зуун мянга гурван зуун жаран хоёр) төгрөгийн үнэлгээ бүхий 2 өрөө орон сууцны байрыг хөрөнгө солилцоогоор төрийн өмчид хүлээн авч Гаалийн ерөнхий газрын харьяа Орхон аймгийн Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө солилцоо хийсэнтэй холбогдуулан Гаалийн ерөнхий газрын харьяа Орхон аймгийн Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 1-р баг, Зэст 1 дүгээр хороолол, 5 дугаар байрны 42 тоот хаягт байрлах, нийт 13,998,822.00 (арван гурван сая есөн зуун ерэн найман мянга найман зуун хорин хоёр) төгрөгийн балансын үнэ, 2,916,421.20 (хоёр сая есөн зуун арван зургаан мянга дөрвөн зуун хорин нэгэн төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 өрөө орон сууцны байрыг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3. Солилцсон орон сууцнуудын зах зээлийн үнэлгээний зөрүү болох нийт 3,463,928.00 (гурван сая дөрвөн зуун жаран гурван мянга есөн зуун хорин найм) төгрөгийг иргэн П.Энхбатаас гаргуулан авах, тооцоо нийлэх.

4. Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Орхон аймгийн Гаалийн газрын дарга Б.Майдармаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1. Солилцсон орон сууцыг хүлээлцэх ажлыг байгууллагынхаа Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

4.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

4.3. Энэхүү шийдвэр гарсантай холбогдуулан данснаас хассан болон төрийн өмчид хүлээн авсан орон сууцны талаар Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх, өмнөх өмчлөгчөөс нэр шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.5. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

